



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 641

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 467 дугаар тогтоолын 2.1 дэх тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 3 нэрийн, нийт 211,811,830.00 (хоёр зуун арван нэгэн сая найман зуун арван нэгэн мянга найман зуун гуч) төгрөгийн балансын үнэ, 205,482,730.11 (хоёр зуун таван сая дөрвөн зуун наян хоёр мянга долоон зуун гучин төгрөг арван нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, "Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Амарсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133002666
28-r_huraldaan.docx



"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Автокран (zoomlion), 86-20 УБЦ улсын дугаар, L5E5H3D346A004078 арлын дугаар, тусгай зориулалтын	2006 2007/01/01	ш	1	119,539,100.00	119,539,100.00	119,539,100.00	-	30,000,000.00
2	Тусгай тоноглолтой Fotop маркийн, 90-42 УНЦ угсрын дугаар, LVBV3ABVXAJ039940 арлын дугаар, ачааны зориулалттай	2010/01/01	ш	1	67,272,730.00	67,272,730.00	60,943,630.11	6,329,099.89	6,400,000.00
3	Зил 433360 маркийн, 58-68 УБГ улсын дугаар, 3464944 арлын дугаар, ачааны зориулалттай	2002/01/01	ш	1	25,000,000.00	25,000,000.00	25,000,000.00	-	3,500,000.00
Нийт дүн				3		211,811,830.00	205,482,730.11	6,329,099.89	39,900,000.00
						(хоёр зуун арван нэгэн сая найман зуун арван нэгэн мянга найман зуун гуч)	(хоёр зуун таван сая дөрвөн зуун наян хоёр мянга долоон зуун гучин төгрөг арван нэгэн мөнгө)	(зургаан сая гурван зуун хорин есөн мянга ерэн есөн төгрөг наян есөн мөнгө)	(гучин есөн сая есөн зуун мянга)